



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/16

Чойбалсан

Г “Хүн болох багаасаа” хүүхдийн спортын Г  
сургалтын төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.3, 16 дугаар зүйлийн 16.4, 16.4.1, 16.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.2.8, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3, 2.5.6, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төсөл хэрэгжүүлэх тухай 13/17 дугаар тогтоол, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/11 дүгээр тогтоолын 2.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн спортын ур чадварыг хөгжүүлж, спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, эрүүл чийрэг бие бялдартай, зөв хүмүүжилтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх зорилгоор хэрэгжүүлэх “Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төслийн төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2.Төсөл хэрэгжүүлэх 600,000,000 (зургаан зуун сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.17 дахь “Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төсөл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (В.Цэнгэлмаа)-д зөвшөөрсүгэй.


3.Төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй сонгон шалгаруулахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газар (Н.Гэрэлцэцэг)-т, шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т тус тус үүрэг болгосугай.

212401297

4.Тус төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж явцын тайланг улирал тутамд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулж, шаардлагатай дэмжлэгийг шуурхай авч хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газар (Б.Чимэддорж), “Хүн болох багаасаа” төслийг удирдах Байнгын ажлын хэсэг (О.Байгалмаа)-т тус тус даалгасугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ш.Ёл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 15 ны өдрийн  
01/16 дугаар захирамжийн хавсралт



“ХҮН БОЛОХ БАГААСАА” ХҮҮХДИЙН СПОРТЫН  
СУРГАЛТЫН ТӨСЛИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

дд	Багц ажлуудын нэр	Төсөв /төг/	Төсөл хэрэгжүүлэгч	Тендэрийн бичиг баримт
1	Сургалт зохион байгуулах зардал /Спортын сургалт/	450,000,000	тендэрт шалгарсан хуулийн этгээд	Ажлын даалгавар
2	Сургалт зохион байгуулах зардал /Хувь хүний хөгжлийн сургалт/	90,000,000	тендэрт шалгарсан хуулийн этгээд	Ажлын даалгавар
3	Теле болон цахим хичээл сургалтын зардал	15,000,000	тендэрт шалгарсан хуулийн этгээд	Ажлын даалгавар
4	Захиалагчийн хяналт болон байнгын ажлын хэсгийн үйл ажиллагааны зардал	15,340,000	Захиалагчийн хяналт тавих ажлын хэсэгт ТББ, иргэний төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулна.	
5	Уралдаан тэмцээний зардал	29,660,000	Батлагдсан удирдамжийн дагуу	
	НИЙТ ДҮН	600,000,000		

---oOo---